

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИЛТ ХУГАЦААНДАА БИЕЛЭХГҮЙ БАЙНА

**Улсын төсвийн 2003 оны
хөрөнгө оруулалт, Засгийн
газрын нөөц сан, улсын
төсвийн хуваарилагдаагүй
болон болзошгүй эрсдлийг
нөхөх зардлын гүйцэтгэл**

Агуулга

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд	4
Аудитын стандартын талаархи мэдэгдэл	4

Аудитын дүн

Улсын төсвийн 2003 оны хөрөнгө оруулалт, их засварын зардал түүний үр дүн	5
Улсын төсвийн хуваарилагдаагүй зардлын зарцуулалт	9
Засгийн газрын нөөц сангийн зарцуулалт	10

Дүгнэлт

13

Холбогдох байгууллагын санал

Санхүү, эдийн засгийн яамны санал	14
-----------------------------------	----

Зөвлөмж

15

Хавсралтууд

1.Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2003 онд хэрэгжүүлсэн барилга байгууламж, арга хэмжээний гүйцэтгэл	16
2.Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх их засварын 2003 оны гүйцэтгэл	
3.Засгийн газрын нөөц сан, төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй болон болзошгүй эрсдлийг нөхөх зардлын гүйцэтгэл	

Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газрын 2004 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн дагуу “Улсын төсвийн 2003 оны хөрөнгө оруулалт, Засгийн газрын нөөц сан, улсын төсвийн хуваарилагдаагүй болон болзошгүй эрсдлийг нөхөх зардлын гүйцэтгэлд” аудит хийв.

Улсын төсвөөс 2003 онд санхүүжүүлсэн барилга, байгууламж, төсөл, арга хэмжээ, их засварын 43,3 хувь буюу 20655,6 сая төгрөгийн, Засгийн газрын нөөц сангийн 27 хувь буюу 1033,4 сая төгрөгийн, улсын төсвийн хуваарилагдаагүй зардлын 52,1 хувь буюу 976,0 сая төгрөгийн зарцуулалтын үр дүнд аудит хийлээ.

Эдгээр арга хэмжээнд УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Гадаад хэргийн яам, Эрүүл мэндийн яам, Түлш, эрчим хүчний ерөнхий газар, Монголын радио телевизийн хэрэг эрхлэх газар, Хил хамгаалах ерөнхий газар, Монгол–Хятадын улсын хилийн шугамыг шалгах комисс зэрэг газрууд хамрагдлаа.

Энэхүү аудитын зорилт нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2003 онд хэрэгжүүлэх барилга, байгууламж, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн

2. Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдлийг нөхөх зардал, улсын төсвийн хуваарилагдаагүй зардлын зарцуулалт, тэдгээрийн үр дүнд дүгнэлт өгөхөд чиглэгдсэн болно.

Гүйцэтгэлийн аудит хийхдээ ярилцлага хийх, түүвэрчилсэн судалгаа явуулах, давтан гүйцэтгэх, нөхцөл байдлын шинжилгээ хийх, баримт материалыг тулган баталгаажуулах, гүйцэтгэлтэй нь харьцуулалт хийх зэрэг аудитын арга зүйг ашигласан болно.

Гүйцэтгэлийн аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга Д.Ганбилэг удирдаж, тус хэлтсийн ахлах аудитор Л.Одгэрэл, шинжээч Ц.Батбаяр, Ц.Эрдэнэчулуун, С.Андруш нар 2004 оны 4 дүгээр сарын 26-наас 6 дугаар сарын 25-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Ерөнхий зүйл

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Дараахь хууль тогтоомжийн заалтыг энэхүү аудитад шалгуур болгон ашиглав. Үүнд:

- 1) Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хууль
- 2) Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан «Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2003 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт»
- 3) Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 39.2.5 дахь заалт
- 4) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хууль
- 5) Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоол
- 6) Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 207 дугаар тушаалаар батлагдсан «Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдлийг нөхөх зардал, төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журам»-ын дагуу сар, жилээр баталсан төсөвт өртөг
- 7) Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 174 дүгээр тушаалаар баталсан « Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журам»

Аудитын стандартын талаархи мэдэгдэл

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын дүн

Улсын төсвийн 2003 оны хөрөнгө оруулалт, их засварын зардал, түүний үр дүн

Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуульд зааснаар хөрөнгө оруулалтад 37046,0 сая төгрөгийг төсвөөс зарцуулах ёстой.

Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 36 дугаар тогтоолоор төсвийн хөрөнгө оруулалтаар 2003 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээнд 37046,0 сая төгрөг, их засварт 2854,0 сая төгрөг, нийт 39900,0 сая төгрөгийг баталсан байна.

Санхүү, эдийн засгийн яамнаас 2003 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн гүйцэтгэлд 44529,4 сая төгрөг, их засварт 3146,4 сая төгрөг санхүүжүүлсэн нь баталсан хэмжээнээс хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж 7483,4 сая, их засвар 292,4 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.


Өмч хувьчлалын 2003 оны төлөвлөгөөнөөс давсан орлогоос Монгол Улсын Ерөнхий сайдын 2003 оны 67 дугаар захирамжаар 6600,0 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд, Монгол Улсын Засгийн газрын 248 дугаар тогтоолоор «Дулаан-шарын гол» орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 2003-2004 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад 229,0 сая төгрөгийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрт тус тус зарцуулахыг Санхүү, эдийн засгийн сайдад зөвшөөрсөн байна.

СЭЗСайдын 2003 оны 276, 318, 364, 396 дугаар тушаал, СЭЗСайд, ДБСайдын 252/181, 392/264 дүгээр тушаал, СЭЗСайд, БСШУСайдын 340/384, 317/370 дугаар тушаал, ЗГХЭГ-ын дарга, СЭЗСайдын 128/363 дугаар тушаал, СЭЗСайд, ЭМСайдын 321/258 дугаар тушаал, СЭЗСайд, ХХААСайдын 321/258 дугаар тушаалаар холбогдох яам, газрын хөрөнгө оруулалт, их засварын ажлыг 12506,5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 4730,7 сая төгрөгөөр бууруулж зохицуулсан байна.

Ийнхүү Санхүү, эдийн засгийн яам холбогдох сайдын хамтарсан тушаалаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, их засварын зардалд зохицуулалт хийсэн төдийгүй Монгол Улсын 2003 оны төсвийн тухай хуульд заасан хэмжээнээс илүү хөрөнгө зарцуулсан байна.

Аудитын дүн

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, их засварын ажилд зарцуулсан нийт хөрөнгийн 87,5 хувь буюу 41705,6 сая төгрөгийг хөрөнгө оруулалтад, 6,6 хувь буюу 3146,4 сая төгрөгийг их засварт, 5,9 хувь буюу 2823,8 сая төгрөгийг тоног төхөөрөмжид тус тус зарцуулжээ.



Улсын төсвийн 2003 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, их засварын ажлын хөрөнгийн зарцуулалтын байдалд гүйцэтгэлийн аудит хийхэд доорхи зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- СЭЗЯ-ны Төрийн сан дахь Төсвийн байгууллагуудын хөрөнгө оруулалт, их засварын зардлын дансны үлдэгдэл 2002 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2140,8 сая төгрөг байсан бол 2003 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2452,9 сая төгрөг болж өмнөх оноос 312,1 сая төгрөгөөр өссөн байна.

Энэ нь СЭЗСайдын 2001 оны 174 дүгээр тушаалаар баталсан улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журмын 3. 20:

«Оны эцэст захиалагч байгууллагын төсвийн хөрөнгийн эх үүсвэрийн болон гүйцэтгэгчийн дансны

Аудитын дүн

үлдэгдлийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэн хаана. Захиалагч гүйцэтгэгчийн эх үүсвэрийн данс банкны жилийн эцсийн тайлангаар үлдэгдэлгүй байна.» гэсэн заалтыг зөрчжээ.

СЭЗЯ-наас 2003 оны 12 дугаар сарын 25-наас 31-ний хооронд хөрөнгө оруулалт, их засварт шилжүүлсэн санхүүжилтийг хөрөнгө оруулалт, их засварын нийт зардлын дүнд харьцуулж үзвэл МРТХЭГазарт 100 хувь буюу 348, 0 сая төгрөг, ХХЕГазарт 50,1 хувь буюу 798,2 сая төгрөг, ГХЯаманд 19,7 хувь буюу 598,3 сая төгрөг, ТЭХЕГазарт 16,7 хувь буюу 9435,5 сая төгрөг болж байна.

Энэ нь ҮАГ-ын өмнөх аудитаар илэрч байсан: «...тайлант оны сүүлийн хоногт олгосон хөрөнгийн зарим хэсэг нь захиалагчийн дансанд үлдэгдэлтэй гарч...тайлагнасан» тохиолдол дахин давтагдсаныг харуулж байна.

Төсвийн байгууллагуудын хөрөнгө оруулалт, их засварын зардлын зарим дансны оны эцсийн үлдэгдлийн зарцуулалтыг шалгахад:

- ❖ Хил хамгаалах ерөнхий газар оны эцэст 141.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ. Санхүү, эдийн засгийн яамны Яам дундын тендерийн хорооны зөвлөмжийн дагуу «Талисман» ХХКомпанитай Камаз маркийн 3 автомашин, чиргүүлийн хамт худалдан авах гэрээг он гарч байгуулсан боловч одоо хүртэл нийлүүлэгдээгүй байна.
- ❖ Монгол-Хятадын улсын хилийн шугамыг шалгах комисс оны эцэст 46,6 сая төгрөгийг Монгол-Хятадын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн хилийн төхөөрөмжийн хээрийн ажилд зарцуулахаар авч үлджээ.
- ❖ Монголын Радио телевизийн хэрэг эрхлэх газар оны эцэст 348,0 сая төгрөгийг Кёкүшюзан Хөгжил сантай гэрээ байгуулан Үндэсний телевизэд явуулын станц худалдаж авахаар авч үлдсэн байна.

Аудитын дүн

Ийнхүү 2003 оны хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжинд зарцуулагдах ёстой 536,1 сая төгрөгийг он дамжуулан дансандаа хадгалж байжээ.

Эрүүл мэндийн яам Баян-Өлгий аймгийн Толбо сумын 10 ортой сумын хүн эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэлд олгох 1,0 сая төгрөг, Завхан аймгийн Тэлмэн сумын 10 ортой сумын хүн эмнэлгийн барилгын ажилд шаардагдах 10.0 сая төгрөгийн санхүүжилтийг тодорхой шалтгаангүй авч үлдсэн байна.

Ингэснээр Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 39.2.5: «Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, тэдгээрийн зардал, төсвөөс зөрүүтэй бол түүний шалтгаан»-ыг тусгаж тайлагнана гэсэн заалтыг дагаж мөрдөөгүй байна.

Гадаад хэргийн яам «Барилга импекс» УҮГ-тай БНХАУ-ын Эрээн дэх Монгол Улсын Консулын газрын барилгын ажлыг 2003 оны 6 дугаар сарын 9-ний өдрөөс эхлэн ажлын 154 хоногт хийж дуусгахаар гэрээ байгуулсан боловч одоо хүртэл Улсын комисст хүлээлгэж өгөөгүй байна.

Уг барилгын гаднах хашаа, зам талбайн тохижилтод 84,0 сая төгрөгийг (батлагдсан эх үүсвэргүй) хэтрүүлэн зарцуулжээ. СЭЗСайдын 2001 оны 174 дүгээр тушаалаар баталсан улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журмын 3.12-т: «Захиалагч төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах үүрэг хүлээнэ» гэсэн заалт зөрчигдөж Гадаад хэргийн яам захиалагчийн үүргээ хангалтгүй гүйцэтгэж байна.

Түлш эрчим хүчний ерөнхий газарт 2003 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд аудит хийх явцад:

Аудитын дүн

- ❖ Нийт 641,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Завхан аймгийн Улиастай-Алдархаан сумдын 37 км, 1х1 мВа, 35 кВ цахилгаан дамжуулах дэд өртөө хугацаандаа ашиглалтанд ороогүй байна.

Энэ нь СЭЗЯ-наас 159,8 сая төгрөгийн хөрөнгийн эх үүсвэр шийдвэрлэгдэхгүй хүлээгдэж байгаатай холбоотой байна.

- ❖ Ховд–Дуутын 35кВт цахилгаан дамжуулах дэд станцын ажлыг төсөвт өртөгт нь багтаан гүйцэтгэсэн боловч 2003 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 50,0 сая төгрөгийн санхүүжилт одоо болтол олгогдоогүйгээс уг объект гэрээт хугацаандаа ашиглалтанд ороогүй 1,6 жил болж байна.

Ийнхүү 2003 онд ашиглалтанд орох ёстой дээрх ажил гэрээт хугацаандаа ашиглалтанд ороогүй байна. Энэ нь хөрөнгийн эх үүсвэр дутагдсан болон ТЭХЕГазар захиалагчийн хяналтын үүргээ хангалтгүй гүйцэтгэж ирсэнтэй холбоотой байна.

УИХ-аас 2003 онд улсын төсвийн хуваарилагдаагүй зардлыг 2030,9 сая төгрөгөөр баталжээ.

Улсын төсвийн хуваарилагдаагүй зардлын зарцуулалт

Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Сангийн сайдын тушаалаар 2011,8 сая төгрөг олгохоор шийдвэрлэснээс 1874,2 сая төгрөгийг олгож 137,5 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

Үүнд Усан спортын сургалтын төвийн бассейнд их засвар хийх зардал, Засгийн газрын үйл ажиллагааны талаархи мэдээллийг хүргэх зорилгоор Засаг дарга нарын захиалсан сонины үнэ, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын бүртгэл, тооллого, үнэлгээний ажлыг зохион байгуулах зардал зэрэг 9 төрлийн арга хэмжээний 137,5 сая төгрөгийг зарцуулаагүй байна.

2003 онд улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас зарцуулсан нийт санхүүжилтийн 0,1 хувь буюу 1,3 сая төгрөгийг «СОС» хүүхдийн хотхонд гэр, гэрийн тавилга

Аудитын дүн

худалдан авахад, 1,0 хувь буюу 18,3 сая төгрөгийг Гадаад орнуудад хийгдэж байгаа сургалт семинар, уулзалт, хэлэлцээр болон айлчлалын арга хэмжээний албан томилолтын зардалд, 1,2 хувь буюу 23,3 сая төгрөгийг буцалтгүй тусламжинд, 1,6 хувь буюу 29,6 сая төгрөгийг УИХ-ын гишүүн болон зарим иргэдийн эмчилгээ сувилгааны зардалд, 1,9 хувь буюу 35,6 сая төгрөгийг Бүртгэл мэдээлэл, улсын өмч хөрөнгийн тооллогын зардалд, 3,1 хувь буюу 58,3 сая төгрөгийг Ном хэвлэлийн зардалд, 3,2 хувь буюу 60,8 сая төгрөгийг Сургалт семинарын зардалд, 4,2 хувь буюу 78,4 сая төгрөгийг Хурал зөвлөлгөөний зардалд, 7,0 хувь буюу 131,1 сая төгрөгийг Зууны мэдээ, Үнэн сонины захиалгын зардалд, 7,4 хувь буюу 120,6 сая төгрөгийг бусад арга хэмжээнд 29,7 хувь буюу 556,7 сая төгрөгийг хөрөнгө оруулалт, их засварын шинж чанартай арга хэмжээнд, 40,6 хувь буюу 760,2 сая төгрөгийг УИХ-ын гишүүдийн тойрогт Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардалд тус тус олгосон байна.

2003 онд болзошгүй эрсдэлийг нөхөх зардалд 6862,0 сая төгрөг төлөвлөсөн боловч хуваарилагдаж, санхүүжилт хийгдээгүй байна.

Засгийн газрын нөөц сангийн зарцуулалт

Монгол Улсын Их Хурлаар баталсан 2003 оны төсвийн тухай хуулиар Засгийн газрын нөөц санд 4000,0 сая төгрөг хуваарилжээ.

Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжаар 5434,1 сая төгрөг олгохоор шийдвэрлэснээс 3821,8 сая төгрөг олгогдож 1612,8 сая төгрөгийг зарцуулаагүй үлдсэн байна.

Үүний дотор багийн засаг дарга нарын бүсчилсэн зөвлөлдөх уулзалтын зардал, Бүсийн тулгуур төв, хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад шаардагдах хөрөнгө, Ардын хувьсгалын 82 жилийн ойг тохиолдуулан Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнахад шаардагдах хөрөнгө, зарим орны Ерөнхийлөгчийн айлчлалын хүлээн авалтын зардал зэрэг 9 төрлийн арга хэмжээний 1384,2 сая төгрөгийг зарцуулаагүй байлаа.

Аудитын дүн

Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойг 2002 онд тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд шаардагдах зардал, Улсын мэргэжлийн хяналтын газрын конторын барилгын засварын зардал, Ардчиллыг шинээр буюу сэргээн тогтоосон орнуудын олон улсын бага хурал, Төрийн ордны засвар тохижилтын зардал зэрэг 14 арга хэмжээний зардлаас 228,1 сая төгрөгийг хэмнэсэн байна.

2003 онд Засгийн газрын нөөц сангаас зарцуулсан нийт санхүүжилтийн 3,5 хувь буюу 133,6 сая төгрөгийг Байгалийн гамшгийн улмаас гарсан хохирлыг барагдуулах, нөхөн сэргээхэд, 6,5 хувь буюу 247,7 сая төгрөгийг Гоц халдварт өвчний голомтыг устгах, урьдчилан сэргийлэхэд, 7,4 хувь буюу 284,7 сая төгрөгийг хурал зөвлөгөөн, сургалт семинар зохион байгуулахад, 8,6 хувь буюу 328,7 сая төгрөгийг гадаадад айлчлал хийх болон гадаадын төлөөлөгчдийг хүлээн авахад, 9,1 хувь буюу 348,8 сая төгрөгийг нэг удаагийн нөхөн олговор, шагнал, хүмүүнлэгийн тусламжинд, 13,4 хувь буюу 512,5 сая төгрөгийг Засгийн газартай гэрээгээр ажил үйлчилгээ нийлүүлсэн байгууллагын ажлын хөлсөнд, 21,5 хувь буюу 823,5 сая төгрөгийг бусад арга хэмжээний зардалд, 30,0 хувь буюу 1142,3 сая төгрөгийг хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын шинж чанартай зардалд тус тус олгосон байна.

Дээрх арга хэмжээг санхүүжүүлсэн хөрөнгө Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 207 дугаар тушаалаар батлагдсан түр журмын дагуу зарцуулагдсан байна.

Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжилт авсан 51 аж ахуйн нэгж, байгууллагад гүйцэтгэлийн аудит хийхэд доорхи зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Үндэсний баяр наадам, Ардын хувьсгалын 82 жилийн ойн баярын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах арга хэмжээнд Засгийн газрын нөөц сангаас 110,0 сая төгрөгийг тусгай данс нээж төвлөрүүлсэн байна. Баяр наадмын төв комиссын тусгай дансыг жилийн эцэст хаагаагүй байна.
- Санхүү, эдийн засгийн яам, 2003 онд Засгийн газрын

Аудитын дүн

нөөц сангаас Засгийн газрын 68 дугаар тогтоолоор Нягтлан бодох, санхүү эдийн засгийн тэргүүний ажилтны III зөвлөлгөөний зардалд олгосон хөрөнгөнөөс 1,7 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцааж төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 207 дугаар тушаалаар батлагдсан Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдлийг нөхөх зардал, төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журмын 5.26-т: «Засгийн газрын нөөц сан болон болзошгүй эрсдлийг нөхөх зардлаас олгосон хөрөнгийг зориулалт бусаар өөр зүйлд буюу өөрийн үйл ажиллагааны зардалд гүйлгэн зарцуулахыг хатуу хориглоно.» гэсэн заалтыг зөрчжээ.

УИХ, Засгийн газрын шийдвэрийн дагуу 2003 онд хөрөнгө оруулалт, их засварын зардалд 47675,8 сая төгрөг зарцуулсан байхад Засгийн газрын нөөц сан, хуваарилагдаагүй зардлаас 1699,0 сая төгрөгийг нэмж хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж, их засварын шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан байна.

Дүгнэлт

Аудитын явцад олж бүрдүүлсэн нотлох зүйлс, баримт материал, хийсэн ажиглалт, судалгаанд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Санхүү, эдийн засгийн яамнаас 2003 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн гүйцэтгэлд 44529,4 сая төгрөг, их засварт 3146,4 сая төгрөг санхүүжүүлсэн нь Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 36 дугаар тогтоолоор баталсан хэмжээнээс хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмж 7483,4 сая, их засвар 292,4 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.
- Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Сангийн сайдын тушаалаар улсын төсвийн хуваарилагдаагүй зардалд 2011,8 сая төгрөг олгохоор шийдвэрлэснээс 1874,2 сая төгрөгийг олгож 137,5 сая төгрөгийг зарцуулаагүй байна.
- Монгол Улсын Их Хурлаар баталсан 2003 оны төсвийн тухай хуулиар болзошгүй эрсдэлийг нөхөх зардалд 6862,0 сая төгрөг төлөвлөсөн боловч хуваарилагдаж, санхүүжилт хийгдээгүй байна.
- Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамжаар Засгийн газрын нөөц санд 5434,1 сая төгрөг олгохоор шийдвэрлэснээс 3821,8 сая төгрөг олгогдож 1612,8 сая төгрөгийг зарцуулаагүй үлдсэн байна.
- 2002 оны 11 дүгээр сарын 21-нээс үйлчилж эхэлсэн Нэгдсэн төсвийн тухай хуулийн 13.3-д заасны дагуу Засгийн газрын нөөц хөрөнгө, болзошгүй эрсдлийн санг бүрдүүлэх, зарцуулах, хуваарилагдаагүй зардлыг зарцуулах журмыг гагцхүү хуулиар зохицуулах ёстой тул Санхүү, эдийн засгийн сайдын баталсан түр журмаар уг асуудлыг цаашид зохицуулах боломжгүй байна.

Дүгнэлт

- ҮАГ-аас өмнө нь хийсэн аудитаар илэрч байсан зарим зөрчил, тухайбал УИХ-аас хөрөнгө оруулалтанд зориулан зарцуулахаар хуульчлан баталсан хэмжээ болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан дүнд багтаан зохицуулалт хийж ажиллаагүй, «...тайлант оны сүүлийн хоногт олгосон хөрөнгийн зарим хэсэг нь захиалагчийн дансанд үлдэгдэлтэй гарч... тайлагнасан явдал дахин давтагдсаар байна.
- Зарим яам, газрын хөрөнгө оруулалт, их засварын ажлыг хэрэгжүүлэх явцдаа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 39.2.5 дугаар заалт, СЭЗСайдын 2001 оны 174 дүгээр тушаалаар баталсан «Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журам»-ын 3.12 дугаар заалтыг тус тус зөрчиж байна.
- ХХЕГ, Монгол-Хятадын улсын хилийн шугамыг шалгах комисс, Монголын Радио телевизийн хэрэг эрхлэх газруудын хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжинд зарцуулагдах ёстой 536,1 сая төгрөгийг он дамжуулан дансандаа хадгалж байжээ.
- Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ хөрөнгийн эх үүсвэрийн дутагдсанаас гэрээний хугацаанд ашиглалтанд ороогүй байна.
- УИХ, Засгийн газрын шийдвэрийн дагуу 2003 онд хөрөнгө оруулалт, их засварын зардалд 47675,8 сая төгрөгийг зарцуулсан байхад Засгийн газрын нөөц сан, хуваарилагдаагүй зардлаас 1699,0 сая төгрөгийг нэмж зарцуулсан байна.

Холбогдох байгууллагын санал

Санхүү, эдийн
засгийн яамны
санал



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД

210448 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэсний түүдэж 5-1, Засгийн газрын II байр,
Утас/факс: 32-02-41, E-mail: ulsan@oms.mn.gov.mn,
http://www.mof.gov.mn

2004.07.29 № 5-29/244
танай 2004.04.06-ны № 231-т

Улсын төсвийн 2003 оны хөрөнгө оруулалт, Засгийн газрын нөөц сан, улсын төсвийн хуваарилагдаагүй болон болзошгүй эрсдлийг нөхөх зардалд хийсэн аудитын дүгнэлтийн тайлбар хүргүүлэх тухай

"Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2003 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл арга хэмжээний жагсаалтыг батлах тухай" Монгол улсын Засгийн газрын 2003 оны 36 дугаар тоот тогтоолоор 37046.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт болон 2854.0 сая төгрөгийн их засварын ажлыг санхүүжүүлэхээр батлагдсан юм.

Гэвч барилга байгууламж, төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн явц, ач холбогдол, гадаадын зээлээр хэрэгжүүлж буй төслүүдийн дотоод эх үүсвэрийн ашиглалтын байдал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон 2003 оны Үндсэн чиглэлд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газар болон захиалагч яам, газруудтай хамтран зарим зайлшгүй зохицуулалтыг батлагдсан дүнд багтаан хийсний зэрэгцээ төсвийн нийт орлогын хэмжээ төлөвлөгөөнөөс давж биелэгдэн нэмэлт эх үүсвэр бий болсон болон, цаг үеийн шаардлагатай уялдуулан хөрөнгө оруулалтын санхүүжилт батлагдсан хэмжээнээс нийт дүнгээрээ 7.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн болно. Нэмэгдэл санхүүжилтийг 2003-2004 оны өвлийн их ачааллын үед Улаанбаатар хотын дулаан хангамжийг сайжруулах, "Монголд зочлох жил"-ийн хүрээнд Сүхбаатарын талбайг шинэчлэх, "Мянганы зам" хөтөлбөрийн дагуу ашиглалтад оруулсан замыг санхүүжүүлэх, хандивлагчдын өмнө Монголын Засгийн газрын хүлээсэн үүргийг биелүүлэх, бүс нутгийг хөгжүүлэх үзэл баримтлалыг хэрэгжүүлэх, террорист үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх зэрэг түргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна.

Цаг үеийн зайлшгүй шаардлагаас үүдэн батлагдсан төлөвлөгөөнөөс давуулж санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний тайлбарыг хавсралтаар харуулав.

Тухайн төсөл, арга хэмжээг хүлээн авсан улсын комиссын актыг үндэслэж, эцсийн санхүүжилтийг тухайн төсвийн жилд нь багтаан олгох, он дамжсан өр, авлага

08 1458

Холбогдох байгууллагын санал

үүсгэхгүй байх шаардлагатай уялдан зарим тохиолдолд захиалагчдын хөрөнгө оруулалт, их засварын зардлын дансны жилийн эцсийн үлдэгдэл 2002 оныхоос нэмэгдсэн байгаа. Энэ нь тухайн захиалагч яам, газруудын ажлын зохион байгуулалттай холбоотой хэдий ч зарим бодит шалтгаан нөлөөлсөн байна. Тухайлбал ХХЕГ-т нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийн гүйцэтгэчийг шалгаруулах ажилд тендерийн гомдол гарч, шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахыг түдгэлзүүлснээс, мөн түүнчлэн МРТХЭГ-т нийлүүлэгдэх явуулын станцын иж бүрдлийг манай мэргэжилтнүүд Японд очиж сонголт хийсэн болон гэрээнд угсарч, суурилуулан ашиглалтад оруулсны дараа санхүүжүүлэхээр тусгагдсантай холбогдон батлагдсан хөрөнгийг захиалагчийн буюу төсвийн эрх захирагчийн дансанд нь шилжүүлэн үлдээсэн байна.

Тайлант жилдээ батлагдсан төсвийг зарцуулахгүй үлдсэн тохиолдолд нөхөн олгох боломжгүй болдог тул Төрийн сан дахь тухайн захиалагчийн хөрөнгө оруулалтын дансанд үлдэж, зохих хяналтыг тавьж байхаар зохицуулж өгөхийг төсвийн эрх захирагчид санал хүсэлт болгодог юм. Гадаад хэргийн яамны захиалгаар Эрээн хотод баригдсан Консулын барилгыг төсөвт тусгагдсан 300.0 сая төгрөгөөс илүү санхүүжилт олгогдоогүй болохыг дахин анхаарахыг хүсье.

Танай дүгнэлтийн сүүлийн хэсэгт Улиастай-Алдархаан, Ховд-Дуут сумын цахилгаан дамжуулах шугамууд хугацаандаа ашиглалтад ороогүй тухай дурьдсан нь захиалагчдын буруутай үйл ажиллагаанаас болсон юм. Тухайлбал Засгийн газрын 2003 оны 36 тоот тогтоолоор Улиастай-Алдархаан сумын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөг барихад улсын төсвөөс 162.0 сая төгрөг олгохоор батлагдсан бөгөөд захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээ, шугамын барилгын ажлын гүйцэтгэлийг үндэслэн, 162.0 сая төгрөгийг бүрэн санхүүжүүлсэн байгаа болно.

Мөн Засгийн газрын 2003 оны 36 тоот тогтоолоор батлагдсан хөрөнгөнөөс давсан хөрөнгийг ИНЕГазар санхүүжүүлэх чиглэл өгсөн тул нэмэгдэл хөрөнгийг улсын төсвөөс гаргаагүй юм.

Харин Засгийн газрын 2003 оны 36 тоот тогтоолоор Дуут сумын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөөг барихад улсын төсвөөс 50.0 сая төгрөг батлагдсан бөгөөд ажил нь хийгдээгүй, барилгын ажлын гүйцэтгэлээ баталгаажуулж ирүүлээгүй учир санхүүжилтийг олгоогүй юм.

Захиалагч ТЭХЕГазар нь дээрхи шугамуудын техник хяналтын зардлыг авч байсан боловч уг шугамуудын ажилд хэмжин шалгалт хийж, хяналт тавьж байгаагүй, захиалагчийн үүргээ биелүүлээгүй, хариуцлагагүй ажилласнаас Алдархаан, Дуут сумын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө өнөөдрийг хүртэл ашиглалтад ороогүй байна.

Засгийн газрын нөөц хөрөнгө, улсын төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээс санхүүжих зарим шийдвэрүүдийг СЭЗСайдын 2001 оны 207 дугаар тушаалаар батлагдсан «Засгийн нөөц сан болон болзошгүй эрсдлийг нөхөх зардал,

Холбогдох байгууллагын санал

төвлөрсөн төсвийн хуваарилагдаагүй зардлыг төлөвлөх, зарцуулах, гүйцэтгэлийг тооцох түр журам»-ын 5.19-т «... Засгийн газрын нөөц сан болон улсын төсвийн хуваарилагдаагүй зардлын эх үүсвэрээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, төслийг хариуцан гүйцэтгэх байгууллага нь уг арга хэмжээ, төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсвийг зардлын зүйлээр хийсэн дэлгэрэнгүй тооцооны хамт СЭЗЯамны ТСУЗГ-т ирүүлнэ.», 5.21-т «Санхүүжилтийг уг арга хэмжээ, төслийг хэрэгжилтийн онцлог, үе шатны ажлын гүйцэтгэлтэй уялдуулан бүрэн болон хэсэгчилж олгоно.» гэсэн заалтуудын дагуу он дамжиж хэрэгжиж байгаа болон төслийг хэрэгжүүлэх төсөв төлөвлөгөө, ажлын гүйцэтгэлийн тайлангаа бүрдүүлж авчраагүй зарим төсөл арга хэмжээг 2003 онд дутуу санхүүжүүлсэн болно. Тухайлбал:

Улсын төсвийн хуваарилагдаагүй зардлаас санхүүжүүлсэн МУИС-ын Чоймаа багшийн хэрэгжүүлж буй төсөл, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг тоолох, үнэлэх зэрэг арга хэмжээнүүд он дамжиж хэрэгжиж байгаа тул 16,3 сая төгрөгийг зарцуулаагүй. Мөн Засгийн газраас 1991 онд гаргасан зээллэгийг нөхөн олгох арга хэмжээг иргэдээс гаргасан хүсэлтийн дагуу тухай бүр СЭЗСайдын тушаал гарган санхүүжүүлдэг тул 2003 онд 95 сая төгрөг зарцуулагдаагүй. Бусад төсөл, арга хэмжээнүүдийг Төрийн сангийн газарт бүрдүүлж авчирсан ажлын гүйцэтгэлийн тайлангийн дагуу санхүүжүүлсэн болно.

Засгийн газрын нөөц хөрөнгөөс санхүүжих БНИУ-ын Ерөнхийлөгч М.Сукарнопутриг хүлээн авах, бүсийн тулгуур төв, хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, Ардын хувьсгалын 82 жилийн ойг тохиолдуулан Засгийн газрын хүндэт өргөмжлөөр шагнах зэрэг төсөл арга хэмжээг хариуцан гүйцэтгэх байгууллагууд нь төслийг хэрэгжүүлэх төсөв төлөвлөгөөг ирүүлээгүй тул санхүүжигдээгүй байна. Мөн багийн засаг дарга нарын бүсчилсэн зөвлөлдөх уулзалт зохион байгуулахад 2003 онд нэмж зардал гараагүй тул санхүүжүүлээгүй.

Дээрх тайлбар, саналыг харгалзан аудитын ажлын талаарх зөвлөмж, дүгнэлтээ тусгана гэдэгт найдаж байна.



Ч.УЛААН

Зөвлөмж

Гүйцэтгэлийн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайдад зөвлөж байна:

- ҮАГ-аас өмнөх онуудад хийсэн аудитаар илэрсэн зөрчил, дутагдал давтагдаж байгаад дүгнэлт хийж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах.
- Засгийн газрын нөөц хөрөнгө болон болзошгүй эрсдлийг нөхөн зардал, төсвийн хуваарилагдаагүй зардлыг бүрдүүлэх зарцуулах асуудлыг Нэгдсэн төсвийн тухай хуулийн 13.3-д заасны дагуу хуульчлах санал боловсруулан зохих журмын дагуу шийдвэрлүүлэх
- СЭЗСайдын 2001 оны 174 дүгээр тушаалаар баталсан улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, их засварын ажлыг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих журмын 3. 20:

«Оны эцэст захиалагч байгууллагын төсвийн хөрөнгийн эх үүсвэрийн болон гүйцэтгэгчийн дансны үлдэгдлийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэн хаана. Захиалагч гүйцэтгэгчийн эх үүсвэрийн данс банкны жилийн эцсийн тайлангаар үлдэгдэлгүй байна» гэсэн заалтыг Төсвийн \ байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулинд нийцүүлэн өөрчлөх.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 262071 дугаарын факсаар харилцана уу.

Тэргүүлэх аудитор

Д.ГАНБИЛЭГ